



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 14 өдөр

Дугаар A/565

Улаанбаатар хот

┌ Тооллогын комисс байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын өмч хөрөнгөнд 2020 оны жилийн эцсийн тооллого хийх комиссыг хавсралтаар байгуулсугай.
2. Тооллогын комисс /А.Мөнгөн/-т даалгах нь:
  - а. Тооллогыг 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс 12 дугаар сарын 25-ны хооронд ажлын 10 хоногт багтаан явуулах;
  - б. Хөрөнгө материалыг нэг бүрчлэн нүдээр үзэн тоолж ажилтнуудын хөрөнгийн ашиглалтын картыг шинэчлэн, кодлож тооллогын бүртгэл үйлдэх;
3. Тооллогын нэгдсэн дүнг 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн дотор гаргаж байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, байгууллагын удирдлагад танилцуулахыг тооллогын комисс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.


ДАРГА



М.БАЯРАА

115060001455

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
даргын 2020 оны 12 дугаар сарын ...<sup>14</sup> өдрийн  
...<sup>1585</sup> дугаар тушаалын хавсралт



Тооллогын комисс байгуулах тухай

Комиссын дарга	А.Мөнгөн	Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд:	Ц.Цэрэндулам	Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
	Т.Азжаргал	Захиргаа санхүүгийн хэлтсийн архивын ажилтан
	Г.Уранчимэг	Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Т.Оюунтуул	Нягтлан бодогч